



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019. 01. 29 № 03

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд асуулга тавьж байна.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусын голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох, "Элэг бүтэн Монгол" хөтөлбөр хэрэгжүүлэхээр заасан билээ.

Монгол улсын хувьд 2017 оны байдлаар хүн амын нийт нас баралтын 25.6 хувийг хорт хавдрын шалтгаант нас баралт эзэлж, энэ нь нийт нас баралтын шалтгааны хоёрдугаарт орж байна. 2017 оны статистикаар жилд 6000 хүн шинээр оношлогдож, 18 мянган хүн хорт хавдартай гэдэг оноштойгоор эмчлэгдэж, хянагдаж байгаагаас жилд 4000 хүн нас барж байна. Хорт хавдрын өвчлөлийн 75 гаруй хувийг элэг, ходоод, уушиг, умайн хүзүү, улаан хоолойн хавдар эзэлж, элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд нэгдүгээрт, умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтаар Азид тэргүүлж байгаа нь харамсалтай байна.

Монгол улсын хувьд 2012 оноос хорт хавдрын эрт илрүүлгийг дэмжигч байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулж байгаатай уялдан эрт үед оношлогдсон өвчтний тоо нэмэгдэх, Хавдар судлалын үндэсний төвийн ачаалал 30 гаруй хувиар нэмэгдсэн мэдээлэл байна.

Иймд хавдрын өвчлөлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар, цаашид сайжруулахад анхааран ажиллах үүднээс дараах асуулгад хариулт ирүүлэхийг хүсье. Үүнд:

1. Салбарын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;
2. Хорт хавдрын эрт илрүүлэлт, үзлэгийн цар хүрээг нэмэгдүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын талаар;

0000000014


3. Хорт хавдрын эмчилгээний чанар, хүчин чадал, хүртээмж, төсөв санхүүгийн талаар;

4. Хүний нөөц, цалин урамшуулал, ажиллах орчны талаар;

5. Эмнэлэгийн тоног төхөөрөмж, байр талбайн хүртээмж, чанарын талаар;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсохыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ОЮУНХОРОЛ

Н.АМАРЗАЯА

Г.МӨНХЦЭЦЭГ

З.НАРАНТУЯА

Н.ОЮУНДАРЬ

М.ОЮУНЧИМЭГ

Б.САРАНЧИМЭГ

Б.УНДАРМАА

А.УНДРАА

Ц.ЦОГЗОЛМАА